

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ,
ХАРИЛЦАН ХАМГААЛАХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газар /цаанид “Хэлэлцэн тохирогч Талууд” гэх/,

Харилцан ашигтай эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлзэн,

Хэлэлцэн тохирогч нэг Талын хөрөнгө оруулагчаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулахад таатай нөхцөл бүрдүүлж оргожүүлэхийг эрмэлзэн,

Хоёр улсын эдийн засгийн хөгжлийг түргэтгэх зорилгоор хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хамгаалах шаардлага байгааг харгалзан,

доорх зүйлийг хэлэлцэн тохиров:

Нэгдүгээр зүйл

Нэр томъёо

Энэхүү Хэлэлцээрийн зорилгод:

(1) “Хөрөнгө оруулагч” гэдэг нэр томъёо нь Хэлэлцэн тохирогч хоёр Талын альны ч тухайд:

а/ Хэлэлцэн тохирогч Талуудын хууль тогтоомжийн дагуу тэдгээрийн иргэн болох хувь хүн,

б/ Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, тухайн Талын нутаг дэвсгэрт эдийн засгийн үйл ажиллагаа бодитойгоор явуулж буй хуулийн аливаа этгээд, үүний дотор компани, корпораци, бизнесийн нэгтгэл болон бусад байгууллага,

в/ Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаагүй боловч энэхүү хэсгийн а/ болон б/ дэд хэсэгт тодорхойлсон хуулийн эсхүл хувь этгээдийн хяналт дор эдийн засгийн үйл ажиллагааг бодитой явуулж буй хуулийн этгээдийг

тус тус хэлнэ.

(2) “Хөрөнгө оруулалт” гэсэн нэр томъёонд бүх төрлийн хөрөнгө түүний дотор:

- а/ хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, түүнчлэн гэдгээртэй холбогдсон дэнчин, барьцаа, саатуулан барьцаалал зэрэг өмчийн эрх болон бусад эрх,
- б/ хувьцаа, хувь буюу хуулийн этгээдэд оролцох аливаа бусад хэлбэрүүд,
- в/ мөнгөн хөрөнгө, бараа үйлчилгээний талаарх /шаардах/ эрх, хэлцлийн биелүүлэхийг эсхүл бусад үйлдлийг гүйцэтгэхийг шаардах аливаа эрх, бонд болон санхүүгийн үнэ цэнэ бүхий өрийн бусад үүрэг,
- г/ оюуны өмчийн эрх, үүний дотор пүүсийн нэр хүнд /гудвил/, зохиогчийн эрх, патент, барааны тэмдэг, үйлдвэрийн загвар, технологийн ажиллабар, “ноу-хау” болон фирмийн нэр,
- д/ хууль тогтоомж болон хэлцлийн дагуу олгогдсон эдийн засгийн үйл ажиллагаа явуулах аливаа эрх, үүний дотор байгалийн баялгийг эрж хайх, олборлох, ашиглах зөвшөөрөл

тус тус багтана.

(3) “Орлого” гэдэг нэр томъёо нь хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон орлого, тухайлбал ашиг, зээллэгтэй холбогдсон хүү, ногдол ашиг, роялти болон хөрөнгийн бусад орлогыг хамрах бөгөөд гэхдээ зөвхөн эдгээрээр үл хязгаарлагдана:

(4) “Нутаг дэвсгэр” гэдэг нэр томъёог Хэлэлцэн тохирогч Тал тус бүрийн нутаг дэвсгэрийг Хэлэлцэн тохирогч Талуудын хууль тогтоомжоор олон улсын эрхийн дагуу тодорхойлсныг ойлгоно.

Хоёрдугаар зүйл

Хэрэглэх хүрээ

Энэхүү хэлэлцээрийг Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт хууль тогтоомжийн нь дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчаас оруулсан хөрөнгийн тухайд түүнийг энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө буюу хойно оруулснаас үл хамааран дагаж мөрдөнө.

Гуравдугаар зүйл

Хөхиүлэн дэмжих, оруулахыг зөвшөөрөх

(1) Хэлэлцэн тохирогч Тал бүр өөрийнхөө нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчаас хөрөнгө оруулахыг хөхиүлэн дэмжиж, тийм хөрөнгө оруулалтыг хууль тогтоомжийнхоо дагуу зөвшөөрнө.

- (2) Хэлэлцэн тохирогч аль ч Тал өөрийнхөө нутаг дэвсгэрт хөрөнгө тийшхүү оруулахтай холбогдсон шаардлагатай зөвшөөрөл олгоход хууль тогтоомжийнхоо дагуу туслалцаа үзүүлнэ.

Дөрөвдүгээр зүйл

Хамгаалалт, нөхцөл

- (1) Хэлэлцэн тохирогч аль ч Тал нутаг дэвсгэрийнхээ хүрээнд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчаас оруулсан хөрөнгийг хамгаалах бөгөөд удирдах, хэвийн байлгах, ашиглах, эзэмших, орготгох буюу захиран зарцуулахад зохистой бус, эсвэл ялгаварлан гадуурхах арга хэмжээ авахгүй.
- (2) Хэлэлцэн тохирогч аль ч Тал нутаг дэвсгэрт нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчаас оруулсан хөрөнгөд ямагт шударга, эрх тэгш нөхцөл олгоно. Хэлэлцэн тохирогч Тал бүр Хэлэлцэн тохирогч нөгөө талын хөрөнгө оруулагчид болон тэдгээрийн хөрөнгө оруулалтад өөрийн хөрөнгө оруулагчид, тэдний хөрөнгө оруулалтад олгодгоос дутуугүй таатай нөхцлийг, хэрвээ өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд гуравдагч аливаа улсын хөрөнгө оруулагч, тэдний хөрөнгө оруулалтад олгож буй нөхцөл нь илүү таатай бол тэрхүү таатай нөхцлийг олгоно.
- (3) Хэрвээ Хэлэлцэн тохирогч аль нэг Тал худалдааны чөлөөт бүс, гаалийн холбоо, эсхүл нийтийн зах зээл, эсхүл бүс нутгийн төсөөтэй бүтэц бүрдүүлж буй хэлэлцээр, нэг бол татварыг давхардуулахаас зайлсхийсэн хэлэлцээрийн улмаас аливаа гуравдагч улсын хөрөнгө оруулагчид тусгайлсан давуу тал олгож байгаа бол тэдгээр давуу талыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчид олгох үүрэг хүлээхгүй.

Тавдугаар зүйл

Мөнгөн хөрөнгийг чөлөөтэй гуйвуулах

- (1) Нутаг дэвсгэрт нь хөрөнгө оруулалт хийгдсэн Хэлэлцэн тохирогч Талын үндэсний хууль тогтоомжийн дагуу төлөх татвар болон бусад төлбөрийг хийсний дараа хөрөнгө оруулалт буюу орлоготойгоо холбогдсон мөнгөн төлбөрийг чөлөөтэй гуйвуулах бололцоог Хэлэлцэн тохирогч аль ч Тал хөрөнгө оруулагчид олгоно.

Тэдгээр гуйвуулгад:

- а/ ашиг, орлого, үйлчилгээний болон зуучлалын орлого,
 б/ зээлийн төлбөрт зориулсан хөрөнгө,
 в/ хөрөнгө оруулалтыг ашиглаж удирдахтай холбогдсон хөрөнгө,

г/ эгэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 2 дугаар заалтын /в/, /г/, /д/ дэд заалтад дурдсан эрхээс үүдэн гарч байгаа роялти болон бусад төлбөр,

д/ хөрөнгө оруулалтыг хэвийн байлгах, хөгжүүлэхэд шаардагдах нэмэгдэл хөрөнгө оруулалт,

е/ хөрөнгө оруулалтыг бүхэлд нь буюу хэсэгчлэн татан буулгасан буюу худалдсанаас олсон орлого (ортгийн болзолгүй өсөлтийг бодолцон),

ж/ гадаадын ажиллагчдын цалин хөлс болон бусад төлбөр,

з/ бусад эх үүсвэрээс хууль ёсоор олсон орлого

тус тус хамрагдана.

- (2) Гуйвуулгыг чөлөөтэй хөрвөх валютаар зүй бусын сааталгүйгээр гүйцэтгэнэ. Тэдгээр гуйвуулгыг нутаг дэвсгэрт нь хөрөнгө оруулалт хийгдсэн Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжид тусгагдсан журмын дагуу, гуйвуулга хийх өдөр мөрдөгдөж буй ханшийг баримтлан гүйцэтгэнэ.

Зургадугаар зүйл

Дайчлан гаргуулах, нөхөн төлөх

- (1) Хэлэлцэн тохирогч аль ч Тал нийгмийн дээд эрх ангийн үүдгээс, үл ялгаварлах үндсэн дээр, хуулийг зохих ёсоор мөрдөх, түүнчлэн үр дүнтэй, шударга нөхөн төлбөр хийх нөхцлөөр гүйцэтгэхээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулалтын тухайд дайчлан гаргуулах, улсын болгох, эсхүл чингэхтэй төсөөтэй аливаа арга хэмжээг шууд эсхүл шууд бусаар авч хэрэгжүүлэхгүй. Нөхөн төлбөрийг, үүний дотор хүүг хөрөнгө оруулалт хийгдсэн валютаар, аливаа сааталгүй, тухайн эрхийг эдэлбэл зохих этгээлд, оршин суугаа буюу байнга амьдрагч байршлаас үл хамааруулан, гүйцэтгэнэ.
- (2) Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэр дэх дайн эсхүл бусад зэвсэгт мөргөлдөөн, хувьсгал, онц байдал эсхүл төсөөтэй тохиолдлын улмаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтад хохирол учирвал нөхөн сэргээх, даатгах, төлбөр хийх буюу бусад нөхөн төлбөрийн тухайд эгэхүү хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 2 дугаар заалтад дурдсан нөхцөл олгогдох ёстой.

Долдугаар зүйл

Эрх шилжих зарчим

- (1) Хэрэв Хэлэлцэн тохирогч аль нэг Тал эсхүл түүний томилсон байгууллага /цаашид "хохирлыг нөхөн төлөгч Тал" гэх/ Хэлэлцэн тохирогч ногоо Талын нутаг дэвсгэр дэх /цаашид "хүлээн авагч Тал" гэх/ хөрөнгө оруулалтын хувьд олгосон баталгааныхаа дагуу хохирлыг нөхөхтэй холбогдсон төлбөрийг хөрөнгө оруулагч /цаашид "нөхөн төлбөр авагч Тал" гэх/-д хийж байгаа бол "Хүлээн авагч Тал" нь:

а/ хөрөнгө оруулалтад хамаарах бүх эрх болон шаардлага "хохирлыг нөхөн төлөгч Талд" шилжиж байгааг,

б/ тэдгээр эрхийг хэрэгжүүлэх болон эрх нилжилтийн дагуу тэдгээр нэхэмжлэлийг гаргуулан авахтай холбогдсон "хохирлыг нөхөн төлөгч Талд" эрхийг

тус тус хүлээн зөвшөөрнө.

- (2) "Хохирлыг нөхөн төлөгч Тал" нь ямар ч нөхцөл байдалд:

а/ 1 дүгээр хэсэгт дурдсан дагуу шилжсэн эрх, нэхэмжлэлийн тухайд анхныхтай адилхан нөхцөл эдлэх болон

б/ холбогдох хөрөнгө оруулалтын тухайд энэхүү Хэлэлцээрийн дагуу "нөхөн төлбөрийг авагч Тал"-д хийгдэх төлбөртэй тэнцүү төлбөрийг энэхүү дүрэм болон шаардлагын дагуу эзэмших

эрхтэй байна.

Наймдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аль нэг Тал болон Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хоорондох маргааныг шийдвэрлэх

- (1) Хэлэлцэн тохирогч нэг Тал болон Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хооронд хөрөнгө оруулалттай холбогдон гарах аливаа маргааныг шийдвэрлэхийн тулд энэхүү хэлэлцээрийн 9 дүгээр зүйлд хохирол учруулахгүйгээр /Хэлэлцэн тохирогч Талуудын хоорондох маргаан/, түүнд сонирхогч талууд зөвлөлдөөн хийнэ.

- (2) Эдгээр зөвлөлдөөн нь 6 сарын дотор маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадахгүй бол хөрөнгө оруулагч маргааныг:

а/ нутаг дэвсгэрийн харьяаллаар хуулийн нь эрх мэдэлд хамаарах Хэлэлцэн тохирогч Талуудын шүүхийн байгууллагуудад,

б/ улс болон бусад улсын иргэдийн хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай 1965 оны 3 дугаар сарын 18-нд гарын үсэг зурахад

нээлттэй болсон Вашингтоны Конвенцийн дагуу байгуулагдсан хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх Олон улсын төв (ICSID)-д

в/ хэрвээ талууд өөрөөр тохиролцоогүй бол, олон улсын худалдааны эрхийн НҮБ-ын комисс (UNCITRAL)-ын арбитрын дүрмийн дагуу байгуулагдсан "ad hoc" шүүхийн аль нэгэнд шилжүүлнэ.

(3) Аль ч тал хөрөнгө оруулалттай холбогдсон маргааныг Олон улсын арбитрт шилжүүлэх зөвшөөрлөө бичгээр өгнө.

(4) Маргаанд оролцогч Хэлэлцэн тохирогч Тал хэргийг шийдвэрлэх болон шийдвэр гүйцэтгэх аль ч шатанд хөрөнгө оруулагч нь түүнд олгогдсон баталгааны дагуу хохирлынхоо зарим хэсэгт эсвэл бүхэлд нь нөхөн төлбөр авсан хэмээн гомдол мэдүүлэхгүй.

Есдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудын хоорондох маргааныг шийдвэрлэх

- (1) Энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг хэрэгжүүлэх, тайлбарлахтай холбогдон Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд гарсан маргааныг дипломат шугамаар шийдвэрлэнэ.
- (2) Хэрвээ Хэлэлцэн тохирогч хоёр Тал тэдний хооронд маргаан эхэлснээс хойш 6 сарын дотор тохиролцоонд хүрч чадахгүй бол энэхүү маргааныг Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэгний хүсэлтээр, гурван гишүүгээс бүрдэх арбитрын шүүхэд шилжүүлнэ. Хэлэлцэн тохирогч Тал бүр нэг арбитрыг томилох бөгөөд энэхүү хоёр арбитр нь тохиролцож гуравдагч улсын иргэнийг өөрсдийн даргаар томилно.
- (3) Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэг нь арбитраа томилоогүй бөгөөд тийм томилолт хийх тухай Хэлэлцэн тохирогч нөгөө Талын урилгыг 2 сарын турш хэрэгжүүлээгүй бол арбитрыг, тухайн Талын хүсэлтээр, Олон улсын шүүхийн Ерөнхийлөгч томилно.
- (4) Хэрэв хоёр арбитр тэднийг томилсноос хойш 2 сарын дотор даргаа томилох талаар тохиролцож чадаагүй бол, Хэлэлцэн тохирогч аль нэг талын хүсэлтээр, даргыг Олон улсын шүүхийн Ерөнхийлөгч томилно.
- (5) Энэхүү зүйлийн 3 болон 4 дүгээрт заасан тохиолдолд Олон улсын шүүхийн Ерөнхийлөгч дурдсан үүргийг гүйцэтгэж чадахгүй байх, эсхүл тэрээр Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн бол түүний орлогч, томилолтыг хийх ёстой бөгөөд хэрвээ тэрээр ямар нэг шалтгаанаар дурдсан үүргийг гүйцэтгэж чадахгүй буюу эсвэл Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн бол томилолтыг Хэлэлцэн тохирогч аль ч Талын иргэн биш ахлах шүүгч гүйцэтгэнэ.

- (6) Хэлэлцэн тохирогч Тал бүр арбитрын шүүхийн өөрийн гишүүн болон өөрийгөө төлөөлүүлсний зардлыг заана. Шүүхийн даргын болон бусад зардлыг Хэлэлцэн тохирогч Талууд тэнцүү хувааж төлнө. Хэрэв Хэлэлцэн тохирогч Талууд өөрөөр шийдвэрлээгүй бол, арбитрын шүүх бусад бүх асуудлаарх дүрэм журмаа өөрөө тогтооно.
- (7) Арбитрын шүүхийн шийдвэр нь эцсийн бөгөөд Хэлэлцэн тохирогч Талууд заавал дагаж мөрдөнө.

Аравдугаар зүйл

Бусад үүрэг

- (1) Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хуулийн заалтууд эсхүл олон улсын хуулийн заалтууд энэхүү Хэлэлцээрт зааснаас илүү тааламжтай нөхцлийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтад олгохуйц эрх бүрдүүлж байвал тэдгээр илүү таатай заалт, журам нь энэхүү Хэлэлцээрт зааснаас давамгайлж хэрэглэгдэнэ.
- (2) Хэлэлцэн тохирогч Тал тус бүр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын хувьд хүлээсэн үүргээ сахин биелүүлнэ.

Арван нэгдүгээр зүйл

Өөрчлөлт, нэмэлт оруулах

Хэлэлцэн тохирогч Талуудын харилцан тохиролцсоноор энэхүү Хэлэлцээрт өөрчлөлт оруулж болно.

Арван хоёрдугаар зүйл

Төгсгөлийн заалтууд

- (1) Энэхүү Хэлэлцээр нь түүнийг хүчин төгөлдөр болгох талаар дотоодынхоо хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлсэн тухай сүүлийн мэдэгдэл өгсөн өдрөөс хүчин төгөлдөр болох бөгөөд 10 жилийн туршид хүчин төгөлдөр байна. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал түүнийг цуцлах тухайгаа холбогдох хугацаа дуусахаас өмнө 6 сарын өмнөөс бичгээр мэдэгдээгүй бол дараагийн 10 жилд аяндаа сунгагдаж байна.
- (2) Энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоох талаар албан ёсоор мэдэгдэл өгсөн тохиолдолд нэгээс аравдугаар зүйлийн заалтууд албан ёсоор


мэдэгдэл өгөхөөс өмнө оруулсан хөрөнгө оруулалтын тухайд цаашид нэмэгдэл 10 жилийн хугацаанд мөрдөгдөнө.

Хэлэлцээрийг 1999 оны 12 дугаар сарын 4-ны өдөр Бишкек хотноо монгол, киргиз, орос хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүү гарвал орос хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



ЦАХИМ АШИГЛАЛТЫН ХУВЬ

ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ